

ИХЭР МӨРӨН АУДИТ ХХК



САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Мөрөн сумын Дэлгэрмөрөн цогцолбор сургуулийн 2022 оны санхүүгийн тайлан,
төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

Аудитын код: ХӨА-2023/194/НА-СТА-ТШЗ

Цахим хуудас:
www.audit.mn

Мөрөн сум 2023 он

Хөвсгөл аймаг дахь Төрийн аудитын газрын дарга,
тэргүүлэх аудитор: А.Эрдэнэбаатар

Утас: 88883317 Цахим хаяг: erdenebaatara@audit.gov.mn

Аудитын менежер: Б.Тэгшдэлгэр

Утас: 99089114 Цахим хаяг: tegshdelgerb@audit.gov.mn

Аудитор: Г.Ичинхорлоо

Утас: 88688168 Цахим хаяг: ichinkhorloog@audit.gov.mn

Ихэрмөрөн-Аудит ХХК-ийн захирал Б.Мядагмаа

Утас: 99389208 Цахим хаяг: b_myadagmaaa@yahoo.com

Аудитор Б.Нэргүй

Утас: 99010744 Цахим хаяг: nerguib82@gmail.com

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

АГУУЛГА

1. ХАРААТ БУС АУДИТОРЫН ДҮГНЭЛТ.....	3
Асуудлыг онцолсон хэсэг.....	3
Аудитын гол асуудал.....	3
2. АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ.....	16
3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА.....	17
4. АУДИТЫН ТАЙЛАН.....	17
4.1 Ерөнхий зүйл.....	17
4.2 Материаллаг байдал.....	18
4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт.....	18
4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал.....	18
4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт.....	18
4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт.....	18
4.5.1 Завсрын аудитын талаар.....	18
4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал.....	18
5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ.....	19
6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ.....	20

Товчилсон үгийн жагсаалт

УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
БШУС	Боловсрол, шинжлэх ухааны сайд
БСШУС	Боловсрол, соёл, шинжлэх ухааны сайд
БШУГ	Боловсрол, шинжлэх ухааны газар
УИХ	Улсын их хурал
ТШЗ	Төсвийн шууд захирагч
ИТХ	Иргэдийн Төлөөлөгчдийн Хурал



ХӨВСГӨЛ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

АЗДТГ-ын байр, А корпус 3 давхар,
Мөрөн сум, Хөвсгөл аймаг, 67120
Утас/факс: 7038 3793, Цахим шуудан: khuvsgul@audit.gov.mn
Цахим хуудас: www.audit.mn

2022.02.20 № 01/86
танай _____-ны № _____-т

11
МӨРӨН СУМЫН ДЭЛГЭРМӨРӨН
ЦОГЦОЛБОР СУРГУУЛИЙН
ЗАХИРАЛ Б.ГАНТУЛГА ТАНАА

Өөрчлөлтгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Мөрөн сумын Дэлгэрмөрөн цогцолбор сургуулийн 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Мөрөн сумын Дэлгэрмөрөн цогцолбор сургуулийн 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторовын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторовын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Асуудлыг онцолсон хэсэг

Монгол Улсын Засгийн газрын 2022 оны 91 дүгээр тогтоолын 4 дүгээр хавсралтаар батлагдсан "Хувьсах зардлын дундаж нормативаар төсөв хуваарилах, санхүүжүүлэх журам"-ын 8.7 дахь заалтад төсвийн жилийн эцэст зарцуулагдаагүй үлдсэн мөнгөн хөрөнгийг улсын төсөвт татан төвлөрүүлэлгүйгээр дараагийн төсвийн жилд шилжүүлэн зарцуулахаар заасантай холбоотой мөнгөн хөрөнгө данс 304,937.6 мянган төгрөгийн үлдэгдэлтэй гарсан байна.

Аудитын гол асуудал

Тус байгууллага нь 2022 онд боловсролын байгууллагыг үйл ажиллагааны үр дүн, чанар, гүйцэтгэл, сургалтын хөтөлбөрийн бодит өртөгт суурилсан хувьсах зардлаар санхүүжүүлэх, суралцагчийн сурлагын чанарыг хараат бусаар үнэлэх, багшийн ажлын үр дүнг суралцагчийн сурлагын чанартай уялдуулж үнэлэх, үр дүн бүтээмжид суурилсан цалин хөлсний бодлого хэрэгжүүлэхэд чиглэсэн холбогдох эрх зүйн актуудыг мөрдсөн байна.

Бусад асуудлын хэсэг

Сургуулийн захирал Мөрөн сумын Засаг даргатай хийсэн гүйцэтгэлийн төлөвлөгөөнд 12 зорилтын хүрээнд 42 арга хэмжээг төлөвлөж, 91.0 хувьтай дүгнэгдсэн байна.

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



А. ЭРДЭНЭБААТАР

2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ

2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

/Төгрөгөөр/

Дансны код	Балансын үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	235,355,967.51	596,500,073.44
31	МӨНГӨН ХӨРӨНГӨ	00.00	304,937,582.60
312	Банкинд байгаа бэлэн мөнгө	00.00	304,937,582.60
3121	Төгрөг	00.00	304,937,582.60
31211	Төрийн сангийн харилцах	00.00	304,937,582.60
33	АВЛАГА	00.00	125,368.33
33100	Ажиллагчидтай холбогдсон авлага	00.00	125,368.33
34	УРЬДЧИЛГАА	00.00	26,790,700.00
34600	Урьдчилж гарсан зардал	00.00	26,790,700.00
35	БАРАА МАТЕРИАЛ	235,355,967.51	264,646,422.51
351	Түүхий эд материал	10,755,435.00	9,310,365.00
35130	Эм боох материал	10,755,435.00	9,310,365.00
354	Хангамжийн материал	224,600,532.51	255,336,057.51
35420	Аж ахуйн материал	15,977,300.00	17,789,845.00
35470	Бусад хангамжийн материал	208,623,232.51	237,546,212.51
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	5,200,122,347.26	5,744,631,927.17
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	5,200,122,347.26	5,744,631,927.17
392	Биет хөрөнгө	4,179,884,847.26	4,704,520,927.17
39201	Барилга, байгууламж, орон сууц	3,841,900,785.20	4,123,465,205.80
39202	Хуримтлагдсан элэгдэл	-225,670,714.08	-338,757,220.92
39203	Авто-тээврийн хэрэгсэл	00.00	36,900,000.00
39205	Машин тоног төхөөрөмж (компьютер)	325,473,642.50	559,768,961.40
39206	Хуримтлагдсан элэгдэл	-54,025,095.94	-132,379,648.35
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	244,939,491.49	300,260,491.49
39208	Хуримтлагдсан элэгдэл	-82,213,333.95	-110,489,846.72
39213	Түүх соёл, музейн дурсгалт зүйлс	00.00	5,381,250.37
39214	Бусад үндсэн хөрөнгө	92,354,146.98	221,032,028.98
39215	Хуримтлагдсан элэгдэл	-30,176,976.30	-44,196,413.24
39217	Ном	67,302,901.36	83,536,118.36
393	Биет бус хөрөнгө	1,020,237,500.00	1,040,111,000.00
39301	Програм хангамж	1,012,500.00	1,012,500.00
39302	Хуримтлагдсан элэгдэл	00.00	-202,500.00
39303	Бусад биет бус хөрөнгө	1,019,225,000.00	1,039,301,000.00
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II	5,435,478,314.77	6,341,132,000.61
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	5,435,478,314.77	6,341,132,000.61
51	Засгийн газрын хувь оролцоо	5,435,478,314.77	6,341,132,000.61
511	Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	2,278,163,442.40	2,298,239,442.40
51101	Өмч: - төрийн	2,278,163,442.40	2,298,239,442.40
512	Хуримтлагдсан үр дүн	2,525,963,311.99	3,529,453,072.68
51210	Өмнөх үеийн үр дүн	2,525,963,311.99	2,643,875,386.84
51220	Тайлант үеийн үр дүн	00.00	885,577,685.84
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	631,351,560.38	513,439,485.53
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V	5,435,478,314.77	6,341,132,000.61

2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

/төгрөгөөр/

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	6,608,437,120.93	5,030,712,110.90
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	5,978,951,093.66	4,355,118,690.90
120	Нийтлэг татварын бус орлого	3,419,208,593.66	748,232,890.90
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	3,419,208,593.66	59,619,400.00
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	26,735,150.00	51,479,400.00
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	00.00	8,140,000.00
1200045	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого	3,392,473,443.66	00.00
123	Улсын төсөв орон нутгийн төсөв хоорондын шилжүүлэг	2,559,742,500.00	3,606,885,800.00
123001	Тусгай зориулалтын шилжүүлгийн орлого	2,559,742,500.00	3,606,885,800.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	629,486,027.27	675,593,420.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	32,076,827.27	15,264,420.00
131103	ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	1,550,000.00	00.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	21,893,327.27	9,150,000.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	8,633,500.00	6,114,420.00
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	597,409,200.00	660,329,000.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	597,409,200.00	660,329,000.00
2	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	3,285,480,725.48	4,130,887,740.44
21	УРСГАЛ ЗАРДАЛ	3,285,480,725.48	4,130,887,740.44
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	3,199,897,424.81	3,807,165,822.51
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	2,035,524,874.78	2,463,556,446.90
210101	Үндсэн цалин	1,775,155,738.96	1,689,804,361.97
210102	Нэмэгдэл	204,012,910.74	644,368,251.64
210104	Урамшуулал	56,356,225.08	129,383,833.29
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	287,895,700.15	309,396,220.83
210201	Тэтгэврийн даатгал	204,192,723.48	211,066,924.37
210202	Тэтгэмжийн даатгал	23,348,996.82	24,816,774.37
210203	ҮОМШӨ-ний даатгал	18,005,296.01	19,759,440.57
210204	Ажилгүйдлийн даатгал	5,205,674.36	4,886,702.94
210205	Эрүүл мэндийн даатгал	37,143,009.48	48,866,378.58
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	548,890,200.00	555,701,514.66
210301	Гэрэл, цахилгаан	7,043,975.90	14,999,959.61
210302	Түлш, халаалт	526,390,200.00	507,171,031.12
210303	Цэвэр, бохир ус	15,456,024.10	33,530,523.93
2104	Хангамж, бараа материалын зардал	31,654,706.67	16,792,598.75
210401	Бичиг хэрэг	4,508,227.27	859,450.00
210402	Тээвэр, шатахуун	7,543,500.00	2,043,298.75
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	1,156,774.40	00.00
210404	Ном, хэвлэл	00.00	3,094,400.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	3,788,000.00	00.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	14,658,205.00	10,795,450.00

2105	Нормативт зардал	13,586,010.00	2,156,350.00
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	9,734,810.00	2,156,350.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	3,851,200.00	00.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	53,892,100.00	36,513,820.00
210604	Урсгал засвар	53,892,100.00	36,513,820.00
2107	Томилолт, зочны зардал	1,937,800.00	00.00
210702	Дотоод албан томилолт	1,937,800.00	00.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	21,933,951.00	1,725,000.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	20,925,951.00	00.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	1,008,000.00	00.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	00.00	1,725,000.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	204,582,082.21	421,323,871.37
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	00.00	58,163,040.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	52,527,110.00	60,966,280.00
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	152,054,972.21	302,194,551.37
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	85,583,300.67	323,721,917.93
2132	Бусад урсгал шилжүүлэг	84,583,000.00	323,721,750.30
213205	Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал	82,353,000.00	267,795,950.30
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	2,230,000.00	55,925,800.00
2134	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт	00.00	167.63
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	00.00	167.63
2135	Төсвийн захирагчдаас олгосон санхүүжилт, шилжүүлэг	1,000,300.67	00.00
213503	Төвлөрүүлэх шилжүүлэг	1,000,300.67	00.00
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)	3,322,956,395.45	899,824,370.46
145	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ОРЛОГЫН ДҮН	00.00	5,381,250.37
145002	Үндсэн хөрөнгө, бараа материал худалдсаны олз	00.00	5,381,250.37
225	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН	38,064,160.31	19,627,934.99
225001	Үндсэн хөрөнгө худалдсаны гарз	00.00	19,207,934.99
225005	Үнэ төлбөргүй гарсан зардал	38,064,160.31	420,000.00
4	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ҮР ДҮН (4)=(145-225)	-38,064,160.31	-14,246,684.62
5	НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)	3,284,892,235.14	885,577,685.84

2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

/төгрөгөөр/

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)	3,226,407,188.27	4,341,993,620.00
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	2,586,477,650.00	3,666,400,200.00
120	Нийтлэг татварын бус орлого	26,735,150.00	59,514,400.00
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	26,735,150.00	59,514,400.00
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	26,735,150.00	51,374,400.00
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	00.00	8,140,000.00
123	Улсын төсөв орон нутгийн төсөв хоорондын шилжүүлэг	2,559,742,500.00	3,606,885,800.00
123001	Тусгай зориулалтын шилжүүлгийн орлого	2,559,742,500.00	3,606,885,800.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	639,929,538.27	675,593,420.00

1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	42,520,338.27	15,264,420.00
131103	ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	1,550,000.00	00.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	22,751,638.27	9,150,000.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	18,218,700.00	6,114,420.00
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	597,409,200.00	660,329,000.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	597,409,200.00	660,329,000.00
2	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)	3,133,672,588.27	3,861,229,867.40
21	УРСГАЛ ЗАРДАЛ	3,133,672,588.27	3,861,229,867.40
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	3,048,089,287.60	3,538,007,949.47
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	2,046,841,574.93	2,463,681,815.23
210101	Үндсэн цалин	1,489,582,174.93	1,689,929,730.29
210102	Нэмэгдэл	431,159,400.00	644,368,251.65
210104	Урамшуулал	126,100,000.00	129,383,833.29
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	276,579,000.00	309,396,220.83
210201	Тэтгэврийн даатгал	194,629,700.00	211,066,924.37
210202	Тэтгэмжийн даатгал	20,487,300.00	24,816,774.37
210203	ҮОМШӨ-ний даатгал	16,389,900.00	19,759,440.57
210204	Ажилгүйдлийн даатгал	4,097,400.00	4,886,702.94
210205	Эрүүл мэндийн даатгал	40,974,700.00	48,866,378.58
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	548,890,200.00	555,701,514.66
210301	Гэрэл, цахилгаан	8,000,000.00	14,999,959.61
210302	Түлш, халаалт	526,390,200.00	507,171,031.12
210303	Цэвэр, бохир ус	14,500,000.00	33,530,523.93
2104	Хангамж, бараа материалын зардал	48,167,912.67	3,244,400.00
210401	Бичиг хэрэг	4,531,227.27	150,000.00
210402	Тээвэр, шатахуун	7,300,000.00	00.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	1,156,774.40	00.00
210404	Ном, хэвлэл	9,585,200.00	3,094,400.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	4,646,311.00	00.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	20,948,400.00	00.00
2105	Нормативт зардал	10,742,400.00	00.00
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	7,498,400.00	00.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	3,244,000.00	00.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	52,359,000.00	33,328,300.00
210604	Урсгал засвар	52,359,000.00	33,328,300.00
2107	Томилолт, зочны зардал	1,937,800.00	00.00
210702	Дотоод албан томилолт	1,937,800.00	00.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	21,439,500.00	34,003,120.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	20,431,500.00	5,587,420.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	1,008,000.00	00.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	00.00	28,415,700.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	41,131,900.00	138,652,578.75

210901	Бараа үйлчилгээний бусад зардал	00.00	87,517,328.75
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	41,131,900.00	51,135,250.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	85,583,300.67	323,221,917.93
2132	Бусад урсгал шилжүүлэг	84,583,000.00	323,221,750.30
213205	Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал	82,353,000.00	267,295,950.30
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	2,230,000.00	55,925,800.00
2134	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт	00.00	167.63
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	00.00	167.63
2135	Төсвийн захирагчдаас олгосон санхүүжилт, шилжүүлэг	1,000,300.67	00.00
213503	Төвлөрүүлэх шилжүүлэг	1,000,300.67	00.00
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2)	92,734,600.00	480,763,752.60
5	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (5)	92,734,600.00	175,826,170.00
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	92,734,600.00	175,826,170.00
2200	Дотоод эх үүсвэрээр	92,734,600.00	175,826,170.00
225106	Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал	92,734,600.00	175,826,170.00
6	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (6)=(4)-(5)	-92,734,600.00	-175,826,170.00
7	САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ	-	-
8	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (8)=(3)+(6)+(7)	-	304,937,582.60
9	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	-	-
10	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	-	304,937,582.60

2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

/төгрөгөөр/

Код	Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Хуримтлагдсан дүн	Засгийн газрын хувь оролцооний нийт дүн
C08	2021 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	2,278,163,442.40	2,525,963,311.99	5,435,478,314.77
D01	2020 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	2,278,163,442.40	2,525,963,311.99	5,435,478,314.77
D02	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	00.00	117,912,074.85	117,912,074.85
D03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	2,278,163,442.40	2,643,875,386.84	5,553,390,389.62
D04	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт, бууралт	00.00	00.00	-117,912,074.85
D05	Үндсэн хөрөнгийн өсөлт, бууралт	20,076,000.00	00.00	20,076,000.00
D08	Тайлант үеийн үр дүн	00.00	885,577,685.84	885,577,685.84
D09	2022 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	2,298,239,442.40	3,529,453,072.68	6,341,132,000.61

2.5.1 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан /Улсын төсөв/

/Төгрөгөөр/

ДАНС	ҮЗҮҮЛЭЛТ	ТӨЛӨВЛӨГӨӨ	ГҮЙЦЭТГЭЛ	ДҮН	ХУВЬ
	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	-	(0.00)	0.00	-
2	I. НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	3,667,900,200.00	3,361,462,617.40	306,437,582.60	91.65
21	УРСГАЛ ЗАРДЛЫН ДҮН	3,667,900,200.00	3,361,462,617.40	306,437,582.60	91.65
210	Бараа, үйлчилгээний зардал	3,315,107,900.00	3,038,740,867.10	276,367,032.90	91.66
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	2,643,132,700.00	2,400,241,697.52	242,891,002.48	90.81
210101	Үндсэн цалин	1,938,779,500.00	1,633,275,154.12	305,504,345.88	84.24
210102	Нэмэгдэл	622,278,000.00	639,864,004.48	(17,586,004.48)	102.83
210104	Урамшуулал	82,075,200.00	127,102,538.92	(45,027,338.92)	154.86
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	330,391,500.00	301,537,320.83	28,854,179.17	91.27
210201	Тэтгэврийн даатгал	224,666,200.00	205,722,824.37	18,943,375.63	91.57
210202	Тэтгэмжийн даатгал	26,431,400.00	24,188,074.37	2,243,325.63	91.51
210203	ҮОМШӨ ний даатгал	21,145,100.00	19,256,540.57	1,888,559.43	91.07
210204	Ажилгүйдлийн даатгал	5,286,200.00	4,760,902.94	525,297.06	90.06
210205	Эрүүл мэндийн даатгал	52,862,600.00	47,608,978.58	5,253,621.42	90.06
2106	Эд хогшил худалдан авах	24,500,000.00	24,500,000.00	-	100.00
210601	Багаж, техник, хэрэгсэл	12,000,000.00	12,000,000.00	-	100.00
210602	Тавилга	12,500,000.00	12,500,000.00	-	100.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр	30,990,900.00	30,983,100.00	7,800.00	99.97
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	2,567,400.00	2,567,400.00	-	100.00
210806	Мэдээллийн технологийн зардал	28,423,500.00	28,415,700.00	7,800.00	99.97
2201	Бараа үйлчилгээний бусад зардал	286,092,800.00	281,478,748.75	4,614,051.25	98.39
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	243,457,500.00	238,843,498.75	4,614,001.25	98.10
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	42,635,300.00	42,635,250.00	50.00	100.00
	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	352,792,300.00	322,721,750.30	30,070,549.70	91.48
2132	Бусад урсгал шилжүүлэг	352,792,300.00	322,721,750.30	30,070,549.70	91.48
213205	Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, дэмжлэг	297,366,500.00	267,295,950.30	30,070,549.70	89.89
213209	Нэг удаагийн тэтгэмж урамшуулал	55,425,800.00	55,425,800.00	-	100.00
	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	3,667,900,200.00	3,666,400,200.00	1,500,000.00	99.96

Мөрөн сумын Дэлгэрмөрөн цогцолбор сургуулийн 2022 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

1310	Улсын төсвөөс санхүүжилт	3,606,885,800.00	3,606,885,800.00	-	100.00
131007	УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИЛТ	3,606,885,800.00	3,606,885,800.00	-	100.00
120004	ТӨСӨВТ БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНААС	61,014,400.00	59,514,400.00	1,500,000.00	97.54
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	51,374,400.00	51,374,400.00	-	100.00
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	9,640,000.00	8,140,000.00	1,500,000.00	84.44
4	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	-	(0.00)	0.00	-
5	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	-	304,937,582.60	(304,937,582.60)	-
6	ТӨСВИЙН БУСАД МЭДЭЭЛЛИЙН АНГИЛАЛ	-	-	-	-
61	БАЙГУУЛЛАГЫН ТОО	-	-	-	-
62	АЖИЛЛАГСДЫН ТОО	152.00	152.00	-	100.00
620001	Удирдах ажилтан	1.00	1.00	-	100.00
620002	Гүйцэтгэх ажилтан	119.00	119.00	-	100.00
620003	Үйлчлэх ажилтан	32.00	32.00	-	100.00
63	СУРАЛЦАГЧДЫН ТОО /жилийн дунджаар/	2,607.00	2,607.00	-	100.00
630	Ерөнхий боловсролын сургуульд суралцагчид	2,607.00	2,607.00	-	100.00
630001	Төрийн өмчит ЕБС	2,607.00	2,607.00	-	100.00

2.5.2 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан /Орон нутгийн төсөв/

/Төгрөгөөр/

ДАНС	ҮЗҮҮЛЭЛТ	ТӨЛӨВЛӨГӨӨ	ГҮЙЦЭТГЭЛ	Дүн	Хувь
	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	-	-	-	-
2	I. НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	660,329,000.00	660,328,832.37	167.63	100.00
21	УРСГАЛ ЗАРДЛЫН ДҮН	660,329,000.00	660,328,832.37	167.63	100.00
210	Бараа, үйлчилгээний зардал	660,329,000.00	660,328,832.37	167.63	100.00
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	63,440,200.00	63,440,117.71	82.29	100.00
210101	Үндсэн цалин	63,440,200.00	56,654,576.17	6,785,623.83	89.30
210102	Нэмэгдэл	-	4,504,247.17	(4,504,247.17)	-
210104	Урамшуулал	-	2,281,294.37	(2,281,294.37)	-
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	7,858,900.00	7,858,900.00	-	100.00
210201	Тэтгэврийн даатгал	5,344,100.00	5,344,100.00	-	100.00
210202	Тэтгэмжийн даатгал	628,700.00	628,700.00	-	100.00
210203	ҮОМШӨ ний даатгал	502,900.00	502,900.00	-	100.00
210204	Ажилгүйдлийн даатгал	125,800.00	125,800.00	-	100.00

Мөрөн сумын Дэлгэрмөрөн цогцолбор сургуулийн 2022 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

210205	Эрүүл мэндийн даатгал	1,257,400.00	1,257,400.00	-	100.00
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	555,701,600.00	555,701,514.66	85.34	100.00
210301	Гэрэл цахилгаан	15,000,000.00	14,999,959.61	40.39	100.00
210302	Түлш, халаалт	507,171,100.00	507,171,031.12	68.88	100.00
210303	Цэвэр, бохир ус	33,530,500.00	33,530,523.93	(23.93)	100.00
2106	Эд хогшил худалдан авах	33,328,300.00	33,328,300.00	-	100.00
210604	Урсгал засвар	33,328,300.00	33,328,300.00	-	100.00
	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	660,329,000.00	660,328,832.37	167.63	100.00
1320	ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	660,329,000.00	660,328,832.37	167.63	100.00
132001	Орон нутгийн төсвөөс	660,329,000.00	660,328,832.37	167.63	100.00
4	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	-	-	-	-
5	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	-	0.00	(0.00)	-

2.5.3 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан

ДАНС	ҮЗҮҮЛЭЛТ	Гүйцэтгэл /Төгрөгөөр/
1	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	-
2	I. НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	15,264,420.00
21	УРСГАЛ ЗАРДЛЫН ДҮН	15,264,420.00
210	Бараа, үйлчилгээний зардал	14,764,420.00
2104	Хангамж, бараа материалын зардал	3,244,400.00
210401	Бичиг хэрэг	150,000.00
210404	Ном, хэвлэл	3,094,400.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр	3,020,020.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	3,020,020.00
2201	Бараа үйлчилгээний бусад зардал	8,500,000.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	8,500,000.00
	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	500,000.00
2132	Бусад урсгал шилжүүлэг	500,000.00
213209	Нэг удаагийн тэтгэмж урамшуулал	500,000.00
	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	15,264,420.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	15,264,420.00
131104	Дээд шатны төсвийн захирагчаас төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	9,150,000.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажилагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	6,114,420.00
4	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	-
5	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	-

3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА

3.1 Байгууллага, түүний үйл ажиллагаа

1.6.1 Байгууллагын үйл ажиллагааны чиглэл, зорилго, зорилтын талаар: Мөрөн сумын Дэлгэрмөрөн цогцолбор сургууль нь бага болон суурь, дунд боловсрол олгох сургалтын үйл ажиллагаа явуулдаг, Боловсрол Шинжлэх Ухааны Яамны харьяа байгууллага юм.

Сургуулийн үйл ажиллагааны үндсэн зорилт нь суралцагчдад боловсролын стандартаар тогтоосон бага, суурь, бүрэн дунд боловсрол эзэмшүүлэх, тэдний хөгжих, төлөвших үйл явцыг шинжлэх ухааны үндэстэй удирдах, зохион байгуулах, эцэг, эх, асран хамгаалагчтай хамтран ажиллах, тэдэнд мэргэжлийн зөвлөгөө, туслалцаа дэмжлэг үзүүлэхэд оршино.

Мөрөн сумын Дэлгэрмөрөн цогцолбор сургууль нь 2022 онд “Хамтын үйл ажиллагаа оролцоонд тулгуурлан багшийн хөгжил хичээлийн чанар, хүүхдийн төлөвшил, сурцад арга зүйгээр нөлөөлж ахиц гаргана” гэсэн зорилго тавьж ажилласан ба энэхүү зорилгын хүрээнд багш, сургууль, суралцагч, эцэг эхийн хөгжилд чиглэсэн зорилтуудыг дэвшүүлэн ажилласан байна.

Сургуулийн захирал Мөрөн сумын Засаг даргатай хийсэн гүйцэтгэлийн төлөвлөгөөнд 12 зорилтын хүрээнд 42 арга хэмжээг төлөвлөж, 91.0 хувьтай дүгнэгдсэн байна.

3.2 Байгууллагын гадаад, дотоод орчин

Байгууллагын үйл ажиллагаа явуулж буй хууль эрх зүйн орчны талаар: 2022 онд боловсролын салбарт шинэчлэл хийж, түүнийг дэмжсэн төсвийг батлан хэрэгжүүлэхийг зорьсон байна. Боловсролын тухай хууль, Сургуулийн өмнөх боловсролын тухай хуулийг 2021 онд өөрчлөн найруулснаар гүйцэтгэл, үр дүнд суурилсан санхүүжилтийн тогтолцоог бий болгож, “хувьсах зардал”-ыг улсын төсвөөс санхүүжүүлэх болсон байна.

Тайлант хугацаанд байгууллагын үйл ажиллагаа, санхүү, нягтлан бодох бүртгэлд мөрддөг хууль тогтоомж болон бодлого чиглэлд дараах өөрчлөлт орсон байна. Үүнд:

1. Хөдөлмөрийн тухай хуулийн шинэчилсэн найруулга 2022 оны 1 дүгээр сарын 1-нээс хэрэгжиж эхэлсэн.
2. Төрийн бүх шатны байгууллага, нийтийн алба, тэдгээрийн үйл ажиллагаанд санхүүгийн сахилга бат мөрдүүлж, ил тод байдлыг хангах, үр ашгийг нэмэгдүүлэх, үрэлгэн байдлыг хязгаарлах хяналт тавихад чиглэсэн “Төрийн хэмнэлтийн тухай” хууль хэрэгжиж эхэлсэн.
3. Төрийн үйлчилгээний албан тушаал эрхэлдэг төрийн албан хаагчийн цалингийн доод хэмжээг Засгийн газрын 2022 оны 107 дугаар тогтоолоор тогтоосон ба 2022 оны 192 дугаар тогтоолоор эрүүл мэндийн салбараас бусад төрийн үйлчилгээний байгууллага болон төрийн байгууллагын хэвийн үйл ажиллагааг хангахад туслах албан тушаалын цалингийн доод хэмжээг өөрчлөн тогтоосон байна.
4. Боловсролын салбарт хийж байгаа шинэчлэл, үйл ажиллагаа, төсөв санхүүг дэмжсэн шийдвэрийг Засгийн газар, салбарын яамнаас гаргаж мөрдүүлсэн байна. Тухайлбал:
 - Засгийн газрын 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн 403 дугаар тогтоолоор Засгийн газрын хэрэгжүүлэгч агентлаг Боловсролын ерөнхий газрыг байгуулсан ба 2022 оны 131 дүгээр тогтоолоор Боловсролын ерөнхий газрын даргыг Сургуулийн өмнөх болон бага, дунд боловсролын, мэргэжлийн боловсролын, техникийн боловсролын сургалтын байгууллагын төсвийн төвлөрүүлэн захирагчаар баталсан байна.
 - Засгийн газрын 2022 оны 91 дүгээр тогтоолоор “Сургуулийн өмнөх боловсрол эзэмшүүлэхэд нэг суралцагчдад хувьсах зардлын дундаж норматив, түүний бүрэлдэхүүн”, “Төрийн болон орон нутгийн өмчит цэцэрлэг, ерөнхий боловсролын

сургуулийн нэг суралцагчид ногдох хувьсах зардлын байршил, хэв шинж, хүүхдийн тооноос хамаарсан өсөн нэмэгдэх итгэлцүүр", "Хувьсах зардлын дундаж нормативаар төсөв хуваарилах, санхүүжүүлэх аргачлал" баталсан байна.

- БШУС-ын 2022 оны А/122 дугаар тушаалаар Засгийн газрын 2022 оны 91 дүгээр тогтоолыг үндэслэн төрийн болон орон нутгийн өмчит сургуулийн өмнөх болон ерөнхий боловсролын сургуулийн үйлчилгээний албан тушаал эрхэлдэг төрийн зарим албан хаагчийн цалингийн хэмжээг тогтоосон.
- БШУС-ын 2022 оны А/170 дүгээр тушаалаар "төрийн болон орон нутгийн өмчийн ерөнхий боловсролын сургууль, цэцэрлэгийн хичээл сургалтын үйл ажиллагааны зардлыг төлөвлөх хуваарилах заавар"-ыг 1 дүгээр, "багшийн тасралтгүй хөгжлийг дэмжих, үйл ажиллагааны санхүүжилт, түүнийг зарцуулах заавар"-ыг 2 дугаар, "цахим хэрэглээний зардлыг төлөвлөх, хуваарилах заавар"-ыг 3 дугаар, "тоног төхөөрөмжийн нөхөн хангалтын зардлыг төлөвлөх хуваарилах, санхүүжүүлэх зааврыг 4 дүгээр хавсралтаар тус тус баталсан байна.
- БШУС-ын 2022 оны А/259 дүгээр тушаалаар "Цэцэрлэг, ерөнхий боловсролын багшийг эрүүл мэндийн нэмэлт үзлэг, оношилгоонд хамруулах заавар"-ыг баталсан байна.
- БШУС-ын 2022 оны А/430 дугаар тушаалаар багшийн ажлыг үнэлэх журмыг шинэчлэн баталсан.
- БШУС-ын 2022 оны А/452 дугаар тушаал "Хувьсах зардлын тоног төхөөрөмжийн нөхөн хангалтын тухай"
- БШУС-ын 2022 оны А/465 дугаар тушаал " Ерөнхий боловсролын сургуульд кабинет, лаборатори, цахим сургалтын танхим байгуулах, ашиглах нийтлэг журам"
- БШУС-ын 2022 оны А/500 дугаар тушаалаар төрийн болон орон нутгийн өмчийн цэцэрлэг, ерөнхий боловсролын сургуулийн үйл ажиллагааны гүйцэтгэлийн чанар, үр дүнг үнэлж, үр дүнгийн нэмэлт урамшууллын зардлыг санхүүжүүлэхэд баримтлах чиглэлийг баталсан.

Байгууллагын дотоод хяналтын талаар: Засгийн газрын 2011 оны 311 дүгээр тогтоолоор баталсан Аж ахуйн нэгж, байгууллагын үйл ажиллагаанд дотоод хяналт шалгалтыг зохион байгуулах нийтлэг журам"-ийн дагуу сургуулийн захирлын 2022 оны А/43 тоот тушаалаар дотоод хяналт хэрэгжүүлэх ажлын хэсгийг 5 хүний бүрэлдэхүүнтэй баталсан байна.

Дотоод хяналтын ажлын хэсэг нь 2022 онд хэрэгжүүлэх ажлын төлөвлөгөөг 9 дүгээр сард батлуулан, тухайн онд нийт 8 удаа дотоод хяналтыг хэрэгжүүлж, тайлагнасан боловч дотоод хяналтын үр нөлөөг дээшлүүлэх, хяналтаар илрүүлсэн зөрчил, дутагдлыг арилгахад чиглэсэн үйл ажиллагааг сайжруулах шаардлагатай байна гэж үзлээ.

Түүнчлэн 2022 онд сургуулийн захирлын тушаалаар шинээр гарсан дүрэм, журмуудын хэрэгжилтийг хангах, байгууллагын үйл ажиллагааг сайжруулах, төсөв санхүүг зарцуулах, түүнд хяналт тавих, худалдан авах ажиллагааг зохион байгуулах, шинээр гарсан дүрэм, журмын хэрэгжилтийг хангах чиг үүрэг бүхий зөвлөл, ажлын хэсэг, багуудыг томилж ажиллуулсан байна.

Тус сургууль нь 2022 онд Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын 2022 оны 64 дүгээр тогтоолоор төрийн болон орон нутгийн өмчийн эд хөрөнгийн улсын үзлэг тооллогыг зохион байгуулсан байна.

Эдгээр зохион байгуулалтын арга хэмжээний хүрээнд "Байгууллагын санхүүгийн үйл ажиллагааны дотоод хяналтын 1 ба 2 дугаар үе шатны тогтолцоо бий болсон байна" гэж үзлээ.

Байгууллагын удирдлагын хэрэгжүүлж буй дотоод хяналтаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөтэй байна гэж үзлээ.

Тайлант онд Хөвсгөл аймгийн Санхүүгийн хяналт, дотоод аудитын албанаас байгууллагын үйл ажиллагаа, санхүү, дотоод хяналтад хяналт шалгалт хийж төсвийн гүйцэтгэлийн зарцуулалт, анхан шатны баримтын бүрдэл нь хуульд нийцсэн, бүртгэлээр тавих хяналт сайн, санхүү бүртгэлийн үйл ажиллагаа “Хангалттай” гэж дүгнэсэн байна.

3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Мөрөн сумын Дэлгэрмөрөн цогцолбор сургуулийн 2022 оны жилийн эцсийн санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккруэл сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэж, Төсвийн тухай хуулийн 54.4, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 8 дугаар зүйлд заасан иж бүрдийн дагуу бэлтгэж толилуулсан байна гэж үзлээ.

Харин төсвийн гүйцэтгэлийн тайланг мөнгөн сууриар бэлтгэж, Төсвийн тухай хуулийн 54 дүгээр зүйлийн 54.5 дахь заалтад заасан заалтын дагуу иж бүрэн ирүүлсэн.

Байгууллагын мөрдөж буй нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийн талаар: Санхүү, нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагаандаа БСШУС-ын 2017 оны А/40 дүгээр тушаалаар баталсан “Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг”-ийг үйл ажиллагаандаа ашиглаж, санхүү, төсөв нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагаандаа УСНББОУС, Засгийн газар, Сангийн яамнаас гаргасан журам, зааврыг мөрдөж ажилласан байна. Тус Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичигт тусгагдсан зарим журам заавар шинэчлэгдсэнтэй холбоотойгоор нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийг өөрийн байгууллагын үйл ажиллагаандаа тохируулан боловсруулах шаардлага тулгарч байна.

3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлтүүд

Мөрөн сумын Дэлгэрмөрөн цогцолбор сургуулийн 2022 оны жилийн эцсийн санхүүгийн тайланг Сангийн сайдын 2006 оны 388 дугаар тушаалаар баталсан “Төсөвт байгууллагад мөрдөх нягтлан бодох бүртгэлийн дансны заавар”-ын дагуу бэлтгэсэн байна. Тайлант хугацаанд нягтлан бодох бүртгэлийн бодлогод өөрчлөлт ороогүй байна.

Тайлант оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 905,653.7 мянган төгрөгөөр өссөн байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

/мянган төгрөгөөр/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
Б	1	2	3=2-1
Мөнгөн хөрөнгө	00.0	304,937.6	304,937.6
Авлага	00.0	125.4	125.4
Бараа материал	235,356.0	264,646.4	29,290.5
Биет хөрөнгө	4,179,884.8	4,704,520.9	524,636.1
Биет бус хөрөнгө	1,020,237.5	1,040,111.0	19,873.5
Нийт хөрөнгө	5,435,478.3	6,341,132.0	905,653.7
Дансны өглөг	00.0	00.0	00.0
Бусад урт хугацаат өглөг	00.0	00.0	00.0
Засгийн газрын хувь оролцоо	5435478.3	6341132.0	905,653.7

Хуримтлагдсан үр дүн	2,525,963.3	3,529,453.1	1,003,489.8
Нийт өр төлбөр ба цэвэр хөрөнгө өмчийн дүн	5,435,478.3	6,341,132.0	905,653.7

Дээрх хүснэгтээс харахад мөнгөн хөрөнгө, бараа материал, өр төлбөр, өмнөх оноос нэмэгдэж, үндсэн хөрөнгө, авлага, эздийн өмчийн данс данс буурсан үзүүлэлттэй байна. Үүнд:

1. Тайлант онд мөнгөн хөрөнгө дансны үлдэгдэл 304,937.6 мянган төгрөгөөр нэмэгдсэн нь улсын төсвөөс хүлээн авсан санхүүжилтийн зарцуулагдаагүй үлдэгдлийг буцаан төвлөрүүлээгүй нь гол нөлөө үзүүлсэн байна.
2. Бараа материал данс өмнөх оноос 29,290.5 мянган төгрөгөөр нэмэгдэхэд бусад хангамжийн материалын дансны өсөлтөд түрээсийн номыг бүртгэсэн нь нөлөөлсөн байна.
3. Үндсэн хөрөнгө данс 524,636.1 мянган төгрөгөөр өссөн нь тайлант онд 846,256.0 мянган төгрөгийн хөрөнгө нэмэгдэж, 87,882.9 мянган төгрөгийн хөрөнгө хасагдаж үндсэн хөрөнгийн элэгдэл 233,737.0 мянган төгрөгөөр нэмэгдсэн байна. АИТХ-ын 2022 оны 12 дугаар сарын 20-ны өдрийн 07 дугаар тогтоолоор сургуулийн барилга 300,000.0 мянган төгрөгийн өртөг нэмэгдүүлсэн, БШУЯ-аас гал тогооны тоног төхөөрөмжийн хангалт хийсэн нь үндсэн хөрөнгийн өсөлтөд гол нөлөө үзүүлсэн байна.
4. Биет бус хөрөнгө 19,873.5 мянган төгрөгөөр өссөн нь 20,076.0 мянган төгрөгийн газрын эрх бүртгэж 202.5 мянган төгрөгийн элэгдэл тооцсонтой холбоотой байна
5. Авлага дансны үлдэгдэл 125.4 мянган төгрөг байгаа нь үйлдвэрчний эвлэлийн татварын тооцооны үлдэгдэл байна.
6. Засгийн газрын хувь оролцоо данс 905,653.7 мянган төгрөгөөр нэмэгдсэн нь Засгийн газрын оруулсан капитал данс 20,076.0 мянган төгрөгөөр өссөн, өмнөх үеийн үр дүн 117,912.1 мянган төгрөгөөр өссөн, дахин үнэлгээний нэмэгдэл данс 117,912.1 мянган төгрөгөөр буурсан, тайлант үеийн үр дүн 885,577.7 мянган төгрөгөөр өссөн байна.

3.5 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

3.5.1 Төсвийн төлөвлөлт

Улсын төсвөөс санхүүжих зардлын төлөвлөлт:

Тус байгууллагын 2022 оны төсвийн төсөлд зардлыг санхүүжүүлэх эх үүсвэрийг улсын төсвөөс 3,361,231.8 мянган төгрөгөөр төлөвлөж дээд шатны төсвийн захирагчид хүргүүлсэн ба төсвийн төслийн саналаас 280,121.8 мянган төгрөгөөр бууруулан 3,081,110.0 мянган төгрөгөөр баталсан байна.

Энэ нь 2022 оны төсвийн төлөвлөлтийг зардлын эдийн засгийн ангиллаар төлөвлөснийг УИХ-аар үр дүн, гүйцэтгэлд суурилсан санхүүжилт олгохоор баталсантай холбоотой, төсвийн жилийн дундуур төсвийн ерөнхийлөн захирагчийн шийдвэрээр удаа дараа нэмэгдүүлэн баталсан байна. Үүнд: Байгууллагын 2022 оны төсвийн зарлагын сар, улирлын хуваарийг БШУС-ын 2022 оны 3 дугаар сарын 24-ны А/105 тоот тушаалаар баталж ирүүлсэн ба 2022 оны 10 дугаар сарын 7-ний өдрийн А/258 дугаар тушаал, 12 дугаар сарын 30-ны өдрийн А/392 тоот тушаалаар тус тус өөрчлөлт оруулж, анхны баталсан төсвийг 586,790.2 мянган төгрөгөөр нэмэгдүүлсэн байна.

Ингэснээр нийт төсвийн зарлага 3,667,900.2 мянган төгрөг болж, 3,606,885.8 мянган төгрөгийг улсын төсвөөс санхүүжүүлэх, 61,014.4 мянган төгрөгийг төсөвт байгууллагын өөрийн орлогоор санхүүжүүлэхээр баталжээ.

Орон нутгийн төсвөөс санхүүжих зардлын төлөвлөлт:

Тус байгууллагын 2022 оны төсвийн төсөлд орон нутгийн төсвөөс 702,140.0 мянган төгрөгийн зардлыг санхүүжүүлэхээр төлөвлөж, Мөрөн сумын ЗДТГ-т хүргүүлсэн байна.

